

Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн харьцуулсан судалгаа

Б. Түвшинтөгс,
Д. Эрдэнэбулган

Эдийн Засгийн Судалгаа, Эрдэм Шинжилгээний Хүрээлэн (ЭЗСЭШХ)

Хураангуй

Энэхүү судалгаанд уул уурхай дээр тулгуурлан амжилттай хөгжсөн Чили, Ботсвана улсыг сонгон авч, тэдгээрийн хөгжилд хүрсэн арга зам, туршлагыг судалж, Монгол улсын үндэсний хөгжлийн бодлогын төлөвлөлт, боловсруулалтын үйл явцад шаардлагатай нийтлэг зүйлсийг танилцуулсан.

Түлхүүр үг:

Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлт, Чили улс, Ботсвана улс, хүн капитал

Улаанбаатар хот

2014



Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн харьцуулсан судалгаа

(Урьдчилсан тайлан)

Эдийн Засгийн Судалгаа,

Эрдэм Шинжилгээний Хүрээлэн

**Судалгааны сэдэв: Үндэсний хөгжлийн бодлого төлөвлөлтийн
харьцуулсан судалгаа**

Судалгааны багийн бүрэлдэхүүн:

Б. Түвшинтөгс МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн Эдийн засгийн
онолын тэнхимийн профессор, Эдийн засгийн судалгаа,
эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал, Эдийн
засгийн ухааны доктор

Д. Эрдэнэбулган Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний
хүрээлэнгийн судлаач, Эдийн засгийн ухааны магистр

МУИС –ийн 5 –р байр, 503 тоот

Бага тойруу 4, СБД

Улаанбаатар хот, Монгол улс

Утас: 976-11-353470

Факс: 976-11-353470

Вэб сайт: www.eri.mn

ГАРЧИГ

ОРШИЛ	4
Нэг. Чили улсын туршлага.....	8
Хоёр. Бүгд найрамдах Ботсвана улсын туршлага.....	12
Ном зүй.....	16

ОРШИЛ

Энэхүү судалгааны зорилго нь уул уурхай дээр тулгуурлан амжилттай хөгжсөн хоёр улсыг сонгон авч, тэдгээрийн хөгжилд хүрсэн арга зам, туршлагыг судалж, Монгол улсын үндэсний хөгжлийн бодлогын төлөвлөлт, боловсруулалтын үйл явцад шаардлагатай нийтлэг зүйлсийг танилцуулахад оршино.

Эдгээр улсуудын туршлагыг судлахад бидэнд ажиглагдсан нийтлэг зүйл бол эдгээр орнууд залуучуудаа илүү боловсролтой болгож улмаар “хөгжлийн гол хөдөлгөх хүч”-ээ болгосон явдал байв.

Улс төр, эдийн засгийн нөхцөл байдал нь ихээхэн өөрчлөгдөж байсан ч хөгжлийн талаар баримтлах улс төр, нийгэм, эдийн засгийн бодлогууд нь тогтвортой, тууштай байсан явдал нь чухамхүү энэ нийтлэг ажиглагдсан шинж чанартай холбоотой. Үүнээс гадна, нийтээрээ эх оронч үзэл санаанд нэгдсэн байдал, улс төрийн намуудын өндөр ёс суртахуун, хөгжлийн урт болон дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулагч мөн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, үнэлэх үүрэгтэй тусдаа бие даасан нэгжүүд байгуулагдан ардчилсан, шударга арга замаар удирдаж байсан зэрэг нь шийдвэрлэх үүрэг гүйцэтгэжээ.

Д.Асэмоглу ба Ж.Робинсон (D.Acemoglu and J.Robinson 2008), В.Ж.Хафф (W.J.Huff 1995), В.Скалли (Scully 1988) ба Т.Растин (Rastin 2003) зэрэг эрдэмтдийн эмпирик болон онолын судалгааны үр дүнгээс харахад улс орнуудын өнөөгийн хөгжил ялгаатай түвшинд байгаа нь тухайн орны эдийн засаг, улс төрийн институцаас хамаардаг байна. Тодруулбал, Т.Растин-ны судалгаанд Сингапур улс капиталист эдийн засгийн загварыг сонгосноороо хэрхэн хурдацтай өсөлтийг бий болгож чадсан талаар судалсан бол В.Скалли судалгаандаа эдийн засгийн хөгжил нь тухайн улсын институцын тогтолцооноос хүчтэй хамаардаг болохыг харуулжээ. Тодруулбал, хуульд өөрчлөлт оруулах, хувийн өмчтэй болох, зах зээлийн нөөцийн хувиарлалтад санал бодлоо тусгаж болохуйц улс төрийн эрх чөлөөтэй улсыг, улс төрийн эрх чөлөөгүй улстай харьцуулахад эдийн засгийн өсөлтийн хурд 3 дахин, үр ашиг 1.5 – 2 дахин их байгааг 115 улсын 1960 – 1980 онуудын тоон мэдээллийг ашиглан харуулсан байна. В.Ж.Хафф нь 1960 оноос хойш Сингапур улсыг эдийн засгийн өндөр өсөлтөд хүргэсэн чухал хүчин зүйл болох Засгийн газрын үүрэг, оролцоог Тайвань, БНСУ болон бусад Азийн улс орнуудтай харьцуулан шинжилжээ. Д.Асэмоглу ба Ж.Робинсон нарын судалгаанд

Өмнөд Америк, Латин Америкийн зарим улсын эдийн засгийн түүхэн тоон мэдээлэлд тулгуурлан урт хугацааны эдийн засгийн өсөлтөд эдийн засгийн институт нь улс төрийн институцаас илүү чухал нөлөөтэй болохыг харуулсан.

Институт хэмээх ойлголтоор нийгмийн бүх агентын харилцан үйлдлийн хөшүүрэг, түүнийг зохицуулах дүрэм журмын цогц ухагдахууныг ойлгоно.

НҮБ –ын Мянганы Чуулганаас “Мянганы хөгжлийн зорилт” – г 2000 онд баталж, улс орнууд “Мянганы хөгжлийн зорилт” –той уялдуулан дунд болон урт хугацааны хөгжлийн зорилтуудыг салбар бүрт боловсруулж, хэрэгжүүлэх арга зам, хэрэгжилтийг хянадаг болжээ. Энэ нь улс оронууд ялгаатай эдийн засаг, улс төрийн институцийг сонгон өөр өөрсдийн замаар хөгжиж болох ч хөгжлийн нэгдмэл тоон үзүүлэлтүүдийн зорилтыг биелүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлсэн гэсэн үг юм. Монгол улс “Мянганы хөгжлийн зорилт” –д суурилсан “Үндэсний хөгжлийн цогц бодлого” –ыг 2007 – 2008 онд боловсруулж, хэрэгжүүлэхэд НҮБ дэмжлэг үзүүлэн, зөвлөх үүрэгтэй оролцож байсан. Гэвч, эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэх, хянах, хариуцлага тооцох механизм тодорхойгүй байсан учраас тус хөтөлбөр тунхагын шинж чанартай хэвээр үлдсэн юм.

Ер нь эдийн засгийн институцыг социалист ба капиталист гэсэн хоёр туйлд хувааж болно. Социалист системд засгийн газар гол үүргийг гүйцэтгэх ба эдийн засгийн ажиллах механизм нь нийтийн өмчит тулгуурладаг бөгөөд хүн бүр нийтийн төлөө ажилладаг. В.Скалли – “Институцын Тогтолцоо ба Эдийн Засгийн Хөгжил” судалгаандаа Дэлхийн II дайны дараахь сэргээн босголт нь буурай хөгжилтэй улс орон бүрийн хувьд XX зуунд тулгарсан томоохон асуудлуудын нэг байсныг цохон тэмдэглэсэн. Тиймээс баян болон ядуу улс орнуудын хоорондын ялгааг арилгах боломжит нэг гарц нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг (ТТЭЗ) гэж үзжээ.

Харин капиталист системийн хувьд нийгмийн оролцогчдын өмчлөх эрх чөлөөтэй, хувийн ашиг сонирхлоо эрхэмлэдэг бөгөөд зах зээлийн өрсөлдөөний дүнд тэнцвэр тогтоно гэж үздэг.

Сүүлийн жилүүдэд улс орнууд социалист, капиталист системийн аль нэгийг шууд сонгохоос татгалзсан. Харин, энэ хоёр системийн давуу талуудыг оновчтой хослуулан, эдийн засгийн хөгжлийн загвараа боловсруулахыг орон бүр өөр өөрийн арга барилаар оролдох болсон. Амжилттай хослуулж чадсан улсын нэг бол Сингапур гэдгийг бид мэднэ. Сингапур улсын Ерөнхий сайд асан Ли Куан (Lee Kuan) 1965 онд “Танд ямар

нэгэн хөгжлийн загвар байсан уу?” гэсэн сэтгүүлчийн асуултанд “Үгүй ээ, би ХонгКонг, Швейцарь, Израйл юу хийж байсан туршлагыг судалж, хэрэгтэй зүйлсүүдийг тусгаж авсан л төдий” хэмээн хариулсан нь чухамхүү энэн хоёр туйлын хувалбарын оновчтой хослолыг өөрийн орны хувьд олохыг эрэлхийлж буйг илтгэж байгаа юм.

В.Ж.Хафф (1995) – нь Сингапур улсын хөгжлийн нууц бол капиталист зах зээлд төрийн оролцооны оновчтой хүрээг тодорхойлж, Засгийн газрын дунд болон урт хугацааны бодлогыг дагаж мөрдөж чадсанд оршдог гэж үзжээ. В.Ж.Хафф-ын судалгааны үр дүнг товчоор дүгнэвэл, Сингапур улсын хурдацтай өсөлт дараахь хэд хэдэн хүчин зүйлсээс шалтгаалсан. Үүнд, Засгийн газрын зүгээс хөдөлмөрийн зах зээлд хийсэн зохицуулалт, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг болон иргэдээ мөнгөн хуримтлалтай болохыг дэмжсэн бодлогууд, мөн төрийн өмчит компаниудын оновчтой менежментийг тодорхойлох, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зэрэг бодлогуудыг дурьдсан байна. Мөн эдийн засаг, улс төрийн шийдвэрүүдийг олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн боловсролтой “элит бүлэг” (elite group) гаргаж байсан. Өөрөөр хэлбэл, тухайн улсын хөгжилд эдийн засаг, улс төрийн “институц” –с гадна боловсролтой, манлайлагч (leader), элит бүлгийн үүрэг оролцоо чухал байсан ба БНСУ, Тайвань зэрэг улсуудын туршлагатай адил байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Хэдийгээр сайн институцыг сонгосон ч тухайн институц тогтворгүй байвал эдийн засгийн тогтвортой хөгжилд хүрч чадахгүй. Иймд, тухайн улсын хөгжил нь эдийн засгийн институцын тогтвортой байдал, түүний тогтолцооноос ихээхэн хамаардаг. Урт хугацааны эдийн засгийн институцын тогтвортой байдал нь улс төрийн институцын өөрчлөлтөөс үл хамааран эдийн засгийн өндөр хөгжилд хүргэж болохыг Д.Асэмоглу ба Ж.Робинсон нар Өмнөд Америк ба Латин Америкийн зарим улсын эдийн засгийн хөгжлийн замналд тулгуурлан харуулсан.

Зах зээлийн эдийн засгийн зарчмаар амжилттай хөгжиж, ядуу буурай орны түвшнээс хөгжингүй орон болж чадсан бодит жишээнүүд цөөнгүй байна. Үүнд, Япон, БНСУ, Тайвань, Сингапур, Өмнөд Африк, Ботсвана болон Чили зэрэг улсуудыг дурьдаж болно.

Энэхүү судалгаанд, амжилттай хөгжиж байгаа улс орнуудын хөгжлийн суурь нөхцөлийн хувьд Монгол улстай ойролцоо Ботсвана болон Чили улсуудын туршлагыг

гүнзгийрүүлэн судалж, эдгээр улсын хөгжлийн суурь нөхцөл болон хөшүүргийг дүгнэн танилцуулна.

Ботсвана улсын хувьд зах зээлийн эдийн засгийн зарчимтай, улс төрийн олон намт системтэй, ардчилсан, хүн ам цөөнтэй (2 сая гаруй), байгалийн баялагт тулгуурлан амжилттай хөгжиж чадсан. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хувьд энэхүү улс нь тодорхой төлөвлөгөөтэйгөөр хөгжиж байгаа нь бидний сонирхлыг татаж байна.

Харин, Чили улс нь иймэрхүү тодорхой төлөвлөгөө цаасан дээр төлөвлөдөггүй боловч бодлогын залгамж чанарыг сайн хадгалан хөгжиж чадсан. Энэ улсын хувьд улс төрийн олон намт системтэй, ардчилсан, зах зээлийн эдийн засагтай улс бөгөөд хүн ам харьцангуй олон (16.6 сая гаруй), эдийн засгийн гол хөдөлгөгч хүч нь зэс, алт зэрэг байгалийн баялагт тулгуурласан улс юм.

Монгол улсын хувьд дээрх хоёр улстай суурь нөхцөлөөрөө төстэй учраас Ботсвана болон Чили улсуудын туршлагыг судлах нь бидний хувьд зайлшгүй шаардлагатай.

НЭГ. ЧИЛИ УЛСЫН ТУРШЛАГА

1.1 Товч танилцуулга

Чили улс нь 1810 онд Испанийн колончлолоос гарч, 1818 онд тусгаар тогтнолоо зарласан. Чилийн хүн ам 1966 онд ойролцоогоор 8.6 сая байсан ба хүн амын 97% нь уугуул иргэд бөгөөд тэдгээрийн 25% нь Испанид төрж өссөн, 66% нь Европ давамгайлсан холимог үндэстэн, 5% нь Итали, үлдсэн 4% хүрэхгүй хэсэг нь бусад үндэстнээс бүрддэг байв.

Хүн амын 70% нь хотод, үлдсэн 30% нь хөдөө мал аж ахуй эрхлэн амьдардаг. Ажиллах хүчний 30 гаруй % болох 2.6 сая нь мал, ойн болон загасны аж ахуйн салбарт, 22% нь үйлчилгээний салбарт, 18% нь аж үйлдвэрийн салбарт, 18% нь худалдаа, 1.6% нь уул уурхайн салбарт ажилладаг.

Чили улс өнөөгийн байдлаар 16.6 сая хүн амтай бөгөөд ажиллах хүчний хувьд Монголоос давуу талтай юм.

1.2 Байгалийн баялаг ба Аж үйлдвэржилт

Чили улсын өнгөрсөн 50 жилд эдийн засгийн гол хөдөлгөгч хүч нь зэс байсан. Тус улсын экспортын гол бүтээгдэхүүн нь хагас болон бүтэн боловсруулсан зэс, зэсэн бүтээгдэхүүн байсан бөгөөд 1960-аад онд 600,000 тонныг экспортолж байв. Үүний 80% -ийг АНУ – ын хоёр томоохон компани болох Анаконда (Anaconda), Кэннэкотт (Kennecott), үлдсэн 20% - ийг үндэсний жижиг болон дунд үйлдвэрүүд бүрдүүлж байжээ. 1966 оны байдлаар Чили улсын зэсийн салбарт 750,000 ам.долларын хөрөнгө оруулалтыг АНУ хийж байсан ба энэ нь Чили улсад оруулсан АНУ - ын нийт хөрөнгө оруулалтын 25% -ыг эзлэж байв. Харин, 1974 – 2000 оны хооронд Чили улсад хийсэн нийт гадаадын шууд хөрөнгө оруулалтын 30.9% -г АНУ, 20.5% -г Испани, 14.3% -г Канад, 5.1% -г Англи, 3.3% -г Япон улс тус тус эзэлж байна.

Чили улсад аж үйлвэржилт гурван үе шаттайгаар явагдаж ирсэн ба эдгээрийг дэлгэрэнгүй танилцуулая.

Нэгдүгээр үе шат: 1939 онд Үндэсний Хөгжил Корпораци байгуулагдан дэд бүтэц, цахилгаан эрчим хүчний салбар, хүнд аж үйлдвэрийн салбарыг дэмжиж эхлэсэн. Улмаар цахилгаан эрчим хүчний салбар хурдацтайгаар хөгжиж аж үйлдвэржилтийн шинэ төрөл хөгжих суурь нөхцөлийг бүрдүүлсэн юм.

Хоёрдугаар үе шат: Гадаадын хөрөнгө оруулалтын ихэнх хэсгээр импортыг орлуулах бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж, аж үйлдвэржилтийг хөгжүүлэхэд зарцуулсан. Гэвч өрсөлдөх чадварын боломжоос хамааран 1950 оны сүүлчээр импортыг орлох бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх аж үйлдвэржилт зогсонги байдалд оржээ.

Гуравдугаар үе шат: 1966 оны байдлаар Чили улсын засгийн газрын зүгээс боловсруулсан төмөр, цаас болон химийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх аж үйлдвэрийг дэмжсэн бодлого хэрэгжүүлж байсан ба сүүлийн жилүүдэд эдгээр бүтээгдэхүүн нь экспортын орлогын 10 гаруй хувийг бүрдүүлж байна.

Эдгээр үйлдвэржүүлэх, эдийн засгийн төрөлжилтийг нэмэгдүүлэх бодлогуудын үр дүнд Чили улсын эдийн засаг нь уул уурхайн салбараас бага хамаардаг болж эдийн засгийн төрөлжилтийг бий болгож чадсан нь өнөөдөр харагдаж байна. Тухайлбал, 2012 оны байдлаар нийт ДНБ-ий зөвхөн 12 хувийг уул уурхай, 60 хувийг үйлчилгээ, 35 хувийг аж үйлдвэрийн салбарууд бүрдүүлж байгаа бөгөөд тус улсын экспортын багцад уул уурхайн бус бүтээгдэхүүн болох жимс жисгэнэ, архи дарс ундаа 4.9 хувь, хүнсний ногоо 7.5 хувь, мал аж ахуйн бүтээгдэхүүн 4.8 хувь, машин, техник тоног төхөөрөмж 1.6 хувийг тус бүр бүрдүүлж байгаа нь тухайн улсад эдийн засгийн төрөлжилтийг нэмэгдүүлэх бодлого амжилттай хэрэгжсэнийг харуулж байна.

2. Эдийн засаг, улс төрийн тогтолцоо ба төлөвлөлт

Чили улсын эдийн засгийн хөгжилд “Хүн капитал” шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн.

Чилийн олон улсын хамтын ажиллагааны удирдлага, Католикийн их сургууль болон Чикагогийн их сургуулиудын хооронд 1959 онд анх “Хүн капиталын хөгжил” гэрээ байгуулагдсан түүхтэй. Энэхүү гэрээний зорилго нь улс орныг тогтвортой хөгжлийн замруу чиглүүлэх “Элит бүлэг”-ийг бий болгоход оршиж байсан. Өөрөөр хэлбэл, уг төсөл нь “Хүн капитал” бүтээх эдийн засгийн туршилтын төсөл байсан юм.

Католикийн их сургуулийн хувьд ямар нэгэн улс төрийн хяналт, хязгаарлалт байхгүй байсан нь энэхүү төслийг хэрэгжүүлж эхлэхэд таатай орчинг бүрдүүлсэн байдаг.

Гэрээний дагуу, анх Чили улсын 26 эдийн засагч Чикагогийн их сургуульд бэлтгэгдсэн ба эдгээр залуус “Чикагогийн хөвгүүд” хэмээх эдийн засагч нар төрөн гарах эхлэл болжээ. Эдгээр хүмүүс Чикагогийн их сургуулийн эдийн засгийн тэнхимийн өндөр

шалгуурыг давж, Америк стандартаар бэлтгэгдсэн сайн эдийн засагч нар байсан бөгөөд Чили улсын эдийн засгийг өнөөгийн өндөр түвшинд хүргэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн.

Дээрх эдийн засагчид Чикагогийн их сургуульд олж авсан мэдлэг, үзэл баримтлалаа хэрхэн Католикийн их сургуулиар дамжуулан Чили улсын нөхцөл байдалд тохируулан түгээн дэлгэрүүлсэн талаар өгүүлье.

1973 он хүртэл Чили улс олон төрлийн ардчиллын системтэй байсан. 1932 - 1973 он хүртэлх хугацаанд Чили улс нь мужийн удирдагчид болон ажилчин ангийн улс төрийн нийгмийн нэгдлийн хамтын удирдлага дор байдаг байсан бол 1973 оны 9 сарын 11 -нд Генерал Аугусто Пиночетоор удирдуулсан Чилийн цэргийн хүчин улс төрийн удирдлагыг хүчээр булаан авсан. Түүний дарангуйлал 1990 он хүртэл үргэлжилж, энэ хугацаанд худалдаа, хөрөнгө оруулалт болон хувийн аж ахуй нэгжүүдийг илүү эрх чөлөөтэй болгосноор олон жилийн туршид хадгалагдаж ирсэн төвлөрсөн тогтолцоот эдийн засгийн бодлогыг халсан.

Юуан Габрейл Валдес (1995) (Juan Gabriel Valdes) – “Пеночитын үеийн эдийн засагч нар” номондоо дурдахдаа, Чикагогийн их сургуульд боловсорсон эдийн засагч нарын хувьд өөрсийн сурсан мэдлэгийг дамжуулах буюу Америк стандартын нийгмийн болон группын эдийн засгийн соёлыг “Нутагшуулах” үйл явц нь хялбар байгаагүй гэжээ.

Уг үйл явцын хамгийн чухал хэсэг нь “үзэл суртлын нутагшуулалт” байсан. Энэ нь ямар нэгэн зорилгыг тодорхой системтэйгээр тухайн улс орны элит бүлгээр дамжуулж тус улсын онцлогт тохируулан, нутагшуулахыг хэлнэ.

Анх 1963 оны 1 сарын 1-нд Чикагогийн их сургуульд бэлтгэгдсэн дараахь профессоруудыг Католикийн их сургуульд үндсэн ажилтнаар авч эхэлсэн байдаг.

1. Марио Алборноз (Mario Albornoz) -Чикагогийн их сургуулийн эдийн засгийн магистр
2. Пабло Бараона, (Pablo Baraona) -Чикагогийн их сургуулийн эдийн засгийн магистр
3. Марио Кордо (Mario Cordo) - Чикагогийн их сургуулийн эдийн засгийн магистр
4. Рикардо Эфрэнч – Дэвис (Ricardo EFrench-Davis) -Чикагогийн их сургуулийн эдийн засгийн магистр
5. Сэргео Муноз (Sergio Munoz) - Чикагогийн их сургуулийн бизнесийн удирдлагын магистр
6. Жюан Навелиан (Juan Naveillian) - Чикагогийн их сургуулийн бизнесийн магистр
7. Ханс Петр Пикер (Hans Peter Picker) - Нортвестерн их сургуулийн бизнесийн удирдлагын магистр
8. Албэрто Валдес (Alberto Valdes) - Чикагогийн их сургуулийн эдийн засгийн магистр
9. Гэртвагнер (GertWagner) -Чикагогийн их сургуулийн эдийн засгийн магистр

Дээрх залуу эрдэмтэд Чикагогийн их сургуульд олж авсан эдийн засгийн мэдлэгтээ тулгуурлан хэрхэн Католикийн их сургуулийн хичээлийн хөтөлбөрийг шинжэчлэн сайжруулах, өөрсдийн нийгэмд эзлэх байр суурийг ямар аргаар бэхжүүлэх вэ? гэсэн томоохон асуудалтай тулгарсан. Тэд асуудлыг юуны түрүүнд Католикийн их сургуулийн удирдлагыг гартаа авч, улмаар оюутануудад орчин үеийн Америк стандартын эдийн засгийн шинжлэх ухааны сайн талыг ойлгуулах замаар шийдвэрлэжээ.

Ингэснээр, Чили улсын ирээдүйн залуу боловсон хүчинг бэлтгэх замаар элит хүрээллээ тэлэх болсон нь хөгжлийн бодлогыг тогтвортой байлгах үндэс болсон.

Хөгжлийн бодлогыг “элит бүлэг” тогтвортойгоор хэрэгжүүлдэг хэдий ч улс төрийн тогтолцооны хувьд намууд нь “Зүүн”, “Төв”, “Баруун” гэсэн гурван хүчинд хуваагддаг. Эдгээр улс төрийн хүчинд хамаарагдах улс төрийн намууд хоорондоо эвсэл байгуулсан байна.

Жишээ нь : Зүүний хүчинд “Ардчилсан намуудын эвсэл”, Нэгдсэн намууд, Чилийн Социалист намуудын эвсэл, Төвийн хүчинд “Ардчилсан намын эвсэл”, “Кристан Ардчилал” зэрэг намуудын хүчтэй эвслүүд багтдаг байна. “Зүүн” ба “Төв”-ийн хүчнийхэн Пиночетын захиргаадалтын эсрэг байр суурьтай, ардчиллыг дэмждэг эвслүүд байдаг бол “Баруун” хүчинд нөлөө бүхий нам эвсэл байхгүй байна.

Католикийн их сургуулийг төгссөн залуу боловсон хүчин нь улсынхаа салбар бүрт удирдах шатны чухал албыг хааж эхэлсэн бөгөөд улмаар улс төрийн намуудыг Чикагогийн хөвгүүд толгойлох болсноор бодлогын уламжлалт чанар хадгалагдаж эхлэсэн. Энэ нь тухайн улсыг тогтвортой хөгжлийн зам руу оруулсан хамгийн чухал шалтгаан байсныг Алан Ангелн судалгаандаа онцолсон байна.

Мөн хөгжлийн бодлого тууштай байхад эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн. Алан Ангелн-“Чилийн Намын Системийн Тогтвортой байдал” судалгаандаа, улс төрийн намуудын чадавхи нь иргэдийн нийгэмлэг, үйлдвэрчний эвлэл, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын нөөц бололцоо болон чадвараас ихээхэн хамаардаг гэдгийг тэмдэглэсэн байдаг.

ХОЁР. БҮГД НАЙРАМДАХ БОТСВАНА УЛСЫН ХӨГЖЛИЙН ТУРШЛАГА

Товч танилцуулга

Хүн ам

Ботсвана улсын хүн ам 1971 – 1991 оны хооронд жилд дунджаар 6.4 хувь өссөн боловч 1991 – 2001 оны хооронд 2.4 хувь болж буурсан. 1991 онд 1.3 сая байсан хүн ам нь 2001 онд 1.6 сая болж өссөн нь хүн амын өсөлтийн хурд удааширсан байгааг илтгэж байна. Хүн амын өсөлтийн прогнозоор Ботсвана улсын хүн амын тоо 2016 онд 1.9 саяд хүрнэ гэж тооцоолсон.¹

Засаглал

Ботсвана нь Ерөнхийлөгчийн засаглалтай бөгөөд Парламент нь Үндэсний Чуулганаас олонхи болж сонгогдсон бүлэг болон Тэргүүлэгчдийн танхимаас (House of Chiefs) сонгогдсон цөөнхийн бүлгүүдээс бүрдэнэ. Харин Ерөнхийлөгч нь Парламентаас сонгогддог.

Ерөнхийлөгч өөрийн эрх мэдлийн хүрээнд Үндэсний Чуулганаас сайд нарыг сонгодог. Мөн дэд ерөнхийлөгчийг нэр дэвшүүлж, парламентаар батлуулдаг.

Үндэсний Чуулган нь иргэдээс шууд сонгогдсон 57 гишүүн болон Ерөнхийлөгчийн тусгайлан сонгосон 4 гишүүнээс бүрдэнэ.

Үндэсний чуулганы сонгууль нь таван жил тутамд явагддаг бөгөөд 2014 онд ээлжит сонгууль болно. Тус улсын засгийн эрхийг 1965 оноос хойш нэг нам (Ардчилсан нам) барьж байгаа тул улс орны хөгжлийн бодлого нь тогтвортой, тууштай хэрэгжиж ирсэн гол хүчин зүйлсийн нэг юм.

Түүхэн хэлхээ

Ботсвана улс нь 1886 оноос хойш 80 жилийн хугацаанд Их Британи улсын колонид байсан. 1966 онд Ботсвана улс тусгаар тогтнолоо тунхаглаж, үндсэн хуулиа батлан,

¹Botswana Vol 1, 2, Government of Botswana.

ардчилсан, парламентын засаглалтай, улс төрийн олон намын тогтолцоотой улс болсон.

Ботсвана улсын үндэсний чуулганы анхны сонгууль 1965 онд болсон бөгөөд Ардчилсан нам ялалт байгуулж үүнээс хойш засгийн эрхийг барьж байна. Сүүлийн сонгуулийн үр дүнгийн тухайд, 2009 оны сонгуульд улс төрийн долоон нам Үндэсний Чуулганы 57 суудлын төлөө өрсөлдсөнөөс Ардчилсан нам 45 суудал авч олонхи болсноор дахин ялалт байгуулсан бол өрсөлдөгч хүчнүүд болох Үндэсний фронт нам 6 суудал, Конгресс нам болон Нэгдсэн хөдөлгөөний эвсэл 5 суудал, бие даан нэр дэвшигч 1 суудал тус тус авсан байна.

Байгалийн баялаг

Ботсвана улс байгалийн баялагаар баян, сүүлийн жилүүдэд олон тооны уул уурхайн хайгуул хийгдэж байна. Экспортын гол бүтээгдэхүүн нь алт, зэс, нүүрс бөгөөд эдийн засгийг хөдөлгөгч гол эх үүсвэр нь алмаз юм. Сүүлийн жилүүдэд Орапа, Летлхакане, Жваненг, Дамтшаа зэрэг алмазын уурхайнууд ашиглалтанд орсон. Алтны уурхайнуудаас Мупанегийн уурхай хамгийн их хүчин чадалтай, жилд дунджаар 795,000 унц алт олборлодог. Нүүрсний уурхайнуудаас Морупулегийн уурхайн олборлолт одоогоор бага байгаа хэдий ч 2.9 тэрбум тонн нүүрсний нөөцтэй нь батлагдаад байна.

Үндэсний Хөгжлийн Төлөвлөгөө ба төлөвлөлтийн үйл явц

Түүхэн хэлхээ

Үндэсний хөгжлийн төлөвлөгөөг Ботсвана улс 1996 оноос боловсруулж эхлэсэн бөгөөд бүх салбарыг хамарсан 20 жилийн хугацаатай цогц төлөвлөгөөг баталдаг. Төлөвлөгөө батлагдсанаас хойш, жил бүр тухайн жилийн үр дүн, алдаа оноогоо хянан шинжилж, төлөвлөгөөгөө улам боловсронгуй болгон шинэчилдэг дүрэмтэй тул уг төлөвлөгөө бодит байдалд нийцсэн, хэрэгжих боломжтой бодлого болж чаддаг.

1996 онд Ерөнхийлөгчийн санаачилгаар үндэсний хөгжлийн цогц бодлогын алсын харааг боловсруулах зорилготой “Ажлын хэсэг” (Task group) –ийг байгуулсан. Анх засгийн газар, иргэдийн төлөөлөгч, хувийн хэвшлийн төлөөлөгчдөөс бүрдсэн 9

гишүүний бүрэлдэхүүнтэй байсан бол дараа жил нь 31 гишүүнтэй болон өргөжиж, үндэсний хөгжлийн төлөвлөгөөг хамтран боловсруулсан.

Эхний үндэсний хөгжлийн төлөвлөгөө батлагдсаны дараа Ботсвана улсын Их Сургуулийн судалгааны баг цаашдын 20 жилийн хөгжлийн төлөвлөгөөний талаар иргэдээс судалгаа авч, засгийн газар, яамд, бүс нутгийн удирдлагууд болон иргэдийн дунд өргөн хүрээний хэлэлцүүлгийн үйл ажиллагааг зохион байгуулсан. Уг үйл ажиллагааны үр дүнд “Үндэсний хөгжлийн төлөвлөгөө” –г иргэдийн өмнө тулгардаг асуудлуудыг илүү тусган сайжруулсан байна.

Хөгжлийн бодлого боловсруулахад бодлогын анализ хийдэг мэргэжлийн судалгааны байгууллага маш чухал үүрэгтэй байдаг ба Ботсвана улсын хувьд, 2002 оноос хойш “Ботсвана институт”-ээс бодлогын төлөвлөлтөнд шаардлагатай техникийн туслалцааг авч байна.

Үндэсний хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах үйл явц

Үндэсний хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа нарийн шат дамжлагатайгаар холбогдох бүх байгууллагуудыг оролцуулан, улс төрийн нам эвслүүдийн саналыг тусган, хариуцсан яам нэгтгэж Үндэсний чуулганаар дараах байдлаар батлуулдаг.

- Санхүү болон Хөгжлийн Төлөвлөгөөний Яам (MFDP) бодлогын гол зорилтуудын хураангуй баримт бичгийг бэлтгэн Эдийн Засгийн Зөвлөлд хүргүүлнэ.
- Эдийн Засгийн Зөвлөл бодлогын хураангуй баримт бичгийг хянаж, холбогдох салбарын яамдад дэлгэрэнгүй зааварчилгаа өгнө. Зааварчилгаанд орон нутгийн засаг захиргаа, иргэдийн нийгэмлэг болон холбоо, байгууллага, мөн хувийн хэвслүүдтэй зөвлөлдөх процессыг тусгасан байна. Энэхүү удирдамжийг холбогдох яамдад хүргүүлнэ.
- Яамд тус бүр төсөвтөө тулгуурлан, өөрийн яамны тэргүүлэх зорилт болон ажлыг тодорхойлсон баримт бичгийг Эдийн Засгийн Зөвлөлд буцаан хүргүүлнэ.
- Засгийн газар “Үндэсний хөгжлийн төлөвлөгөө 9” буюу өмнөх жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар хувийн хэвшил, төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэл, академик институт болон “Алсын хараа зөвлөл” – өөс санал авдаг. Энэхүү саналыг Эдийн Засгийн Зөвлөл, яамдын нарийн бичиг, Төв банкны төлөөлөгчид бодлогын баримт бичигт тусган Санхүү болон Хөгжлийн Төлөвлөгөөний Яам (MFDP) –д өргөн барина.

- Санхүү болон Хөгжлийн Төлөвлөгөөний Яам нь Парламенттай зөвшилцөж, улс төрийн нам, эвслийн санал хүсэлтийг тусган, “Үндэсний хөгжлийн төлөвлөгөө 10” буюу дараа жилийн төлөвлөгөөний нооргийг бэлтгэн “Танхим” (cabinet) – аар хянуулж, батлуулна.
- Танхимаар батлагдсан Үндэсний хөгжлийн төлөвлөгөөг эцсийн байдлаар Үндэсний Чуулган баталснаар уг төлөвлөгөө хүчин төгөлдөр болно.

Дүгнэлт

Бид энэхүү харьцуулсан судалгаандаа уул уурхайн салбарт тулгуурлан амжилттай хөгжсөн хоёр улсыг сонгон авч хөгжилд хүрсэн арга зам, туршлагыг нь судалж үзлээ. Эдгээр орнуудыг амжилтад хүргэсэн суурь нөхцөл нь бодлогын залгамж чанарыг сайн хадгалж чадсанд орших бөгөөд энэхүү залгамж чанарыг хадгалахад “хүн капитал” буюу боловсон хүчин сайн бэлтгэгдсэн байх, улс төрийн тогтолцоо нь энэхүү залгамж холбоо оршин тогтноход саад болохгүй байснаараа онцлогтой. Түүнчлэн, үндэсний хөгжилтэй холбоотой бодлогыг нарийвчилсан судалгаа, шинжилгээнд тулгуурлан боловсруулдагаараа ижил төстэй бөгөөд энэхүү үйл хэрэгт судалгааны байгууллагын оролцоо өндөр байсан байна.

Манай орны хувьд эдгээр орнуудын туршлага сургамжтай хэдий ч шууд хуулбарлан дуурайх нь өрөөсгөл шийдэл болно. Бодлого төлөвлөлтийг улс төрийн намуудын нийтлэг зорилгод үйлчилдэг байхаар тодорхойлох, эргээд энэхүү төлөвлөлтийг аль нам нь ч тууштай хэрэгжүүлдэг байхад үйл ажиллагаагаа чиглүүлэх нь зүйтэй. Тийм ч учраас хөгжлийн бодлогын талаар улс төрийн нэгдмэл ойлголцолд хүрэх нь хөгжлийн бодлого төлөвлөлтийн эхний бөгөөд шийдвэрлэх алхам болох юм. Цаашилбал, бодлогын залгамж халааг хадгалахын тулд улс төрийн намуудад болоод гүйцэтгэх засаглалд ажиллах боловсон хүчнийг илүү чадваржуулах шаардлага тулгарах болно. Чадвартай боловсон хүчнээр байнга шинэчлэгдэж, баяжиж байж бидний дээр хэлэлцсэн бодлогын төлөвлөлт хэрэгжиж, бодлогын залгамж халаа хадгалагдах юм. Бидний судалсан дээрх хоёр орны жишээ ч үүнийг харуулсан.

HOM 3YŦ

Acemoglu, Daron, and James A. Robinson. *The Persistence and Change of Institutions in the Americas*. Southern Economic Journal, 2008.

Arslanalp, Serkan, Fabian Bornhorst, Sanjeev Gupta, and Elsa Sze. "Public Capital and Growth." *IMF Working paper*, July 2010.

Bank of Mongolia. "Monthly Statistical Bulletin." 2013.

Black, Fischer, and Myron Scholes. "The Pricing of Options and Corporate Liabilities." *The Journal of Political Economy*, May/June, 1973: 637-654.

Contessi, Silvio. "An Application of Conventional Sovereign Debt Sustainability Analysis to the Current Debt Crises." *Federal Reserve Bank of St. Louis Review*, May/June 2012: 197-220.

Costa, Carlos Eugenio Ellery Lustosa da. "Public Debt Sustainability." In *Public Debt: the Brazilian Experience*, by Anderson Silva, Lena Carvalho and Medeiros Otavio, 73-89. 2010.

Favero, Carlo, and Francesco Giavazzi. *Debt and The Effect of Fiscal Policy*. Manuscript, 2007.

Giavazzi, Francesco, and Alessandro Missale. "Public Debt Management in Brasil." *NBER Working Paper Series*, March 2004.

Gylfason, Thorvaldur. "Iceland, Rising from the Ashes." In *Prosperity in depth*, by Legatum Institute. 2012.

Huff, W. G. *The Development State, Government, and Singapore's Economic Development since 1960*. World Development, Vol.23, no.8, 1995.

IMF and World Bank. "Guidelines for Public debt management." 9 2003: 28.

IMF and World Bank. "Revisiting the Debt Sustainability Framework for low-Income Countries." January 12, 2012a.

IMF. "Debt Sustainability Analysis." November 1, 2012b.

IMF. "Modernizing the Framework for Fiscal Policy and Public Debt Sustainability Analysis." August 5, 2011.

IMF. "Mongolia: Selected Macroeconomic Indicators." 2013.

IMF. "Sustainable Investment Scaling Up in Low-Income Countries." November 30, 2010.

Melecky, Ales, and Martin Melecky. "Optimal allocation of government debt for the Czech Republic: Managing vulnerability of debt service charges to macroeconomic shocks." *Proceedings of 30th International Conference Mathematical Methods in Economics*.

Ministry of Finance. *Management of contingent liabilities*. (mimeo), 2013.

Ministry of Finance, Mongolia. *Монгол улсын гадаад өрийн тогтвортой байдлын шинжилгээ*. (mimeo), 2013.

Nielsen, Lars Tyge. "Risk-Adjusted Probabilities in the Black Scholes Model." *INSEAD working paper*, 1992.

Rastin, Taymaz. "Model for Development: A Case Study of Singapore's Economic Growth." Canada, 2003.

Roubini, Nouriel. "Debt Sustainability: How to Assess Whether a Country is Insolvent." December 20, 2001.

Scully, Gerald W. *The Institutional Framework and Economic Development*. Journal of Political Economy, Vol.96, No.3, 1988.

World Bank. "When is External Debt Sustainability." February, 2004.

Karen Poniachik. "Chile's FDI Policy: Past Experience and Future." *Global Forum on International Investment*, 2002.